

М.ГОРБАЧЕВ, ДЭН СЯОПИН НАРЫН 1989 ОНЫ ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТ БА МОНГОЛЫН ХУВЬ ЗАЯАНЫ АСУУДАЛ

Ц.Батбаяр*

***Abstract:** The historic meeting between Soviet leader Mikhail Gorbachev and Chinese leader Deng Xiaoping in May 1989 signaled the end of three decades of Sino-Soviet hostility. The talks between Gorbachev and Den Xiaoping in Beijing touched upon the sensitive issues of Sino-Soviet tensions since the 1950s and included the issue of “lost territories.” The author analyzes the speeches by Deng Xiaoping regarding historical issues written in his volume three of Deng Xiaoping’s Selected Works published in the Chinese language in 1993 in Beijing. Deng reiterated his position on the issue of the Mongolian People’s Republic, which was incorporated into the USSR sphere of influence as a “lost territory of China.” The author examines the historical lessons and legacies from the historical meeting held between the leaders of the two neighboring countries and concluded that the historic opportunity emerged for Mongolia to break decade-long isolation and join the international community by the end of the 1980s.*

***Key words:** Deng Xiaoping, Mikhail Gorbachev, Historic Opportunity emerged for Mongolia*

ЗХУКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, ЗХУ-ын Дээд Зөвлөлийн тэргүүлэгчдийн дарга М.С. Горбачев БНХАУ-д 1989 оны 5 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийв. 1949 оноос хойш 40 гаруй жилийн турш Хятад-Зөвлөлтийн харилцаа хэдэн үеийн хүч чармайлтыг гэрчилж, “халуун” болон “хүйтэн” дайн хосолсон сорилтыг давж, хүнд хэцүү, ээдрээ адармаатай бартаат замыг туулсан билээ. БНХАУ-ын ГЯЯ-ны сайд асан Цянь Цичэнь энэ тухай “Би анх 26 настай байхдаа ЗХУ-д 1954 онд ирж билээ. Хятадын дипломатчийн хувьд энэ оронд 10 орчим жил ажилласан. Дараа нь Хятадын Засгийн газрын тусгай төлөөлөгчийн хувьд 1982 оноос 7 жил гаруй Хятад-Зөвлөлтийн улс төрийн зөвлөлдөөнийг хийлгэж, олон ч шөнийг нойргүй өнгөрөөсөн. Тэр өдөр хоёр орны ард түмний олон жил хүсэн хүлээсэн дээд хэмжээний уулзалтын чухал мөч тохиож,

* ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн ЭША, 2009-2013 онд Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Элчин зөвлөх, 2015-2018 онд БН Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар ажиллаж байв. Академич, түүхийн шинжлэх ухааны доктор, ОББЭЭ

би ч өөрийн сэтгэлийн хөдлөлийг барьж чадахгүй байв” гэж дурсжээ.²

1. Дээд хэмжээний уулзалтын өмнөх түүх

1982 оноос Хятад-Зөвлөлтийн засгийн газрын тусгай элч нарын зөвлөлдөх уулзалт жил бүр хоёр удаа Бээжин болон Москвад ээлжлэн болж байв. Энэ нь аливаа хүнээс тэсвэр тэвчээр, ур чадвар шаардсан нэг ёсны урт зайны гүйлт маягийн яриа хэлэлцээ байв. Зөвхөн саад бэрхшээлийг арилгасан цагт л хятад-зөвлөлтийн харилцааг хэвийн болгох болно гэсэн зарчмын байр сууриа хятадын тал чанд барьж, бодит факт, хатуу логик хэрэглэн зөвлөлтийн байр суурь, зөвлөлтийн санаархлыг няцааж, саад бэрхшээлийг арилгах талаар зөвлөлтийн талаас тодорхой алхам хийлгэхийг чармайж байв. 1982 оны 10 дугаар сард эхэлсэн анхны ээлжээс хойш 1986 оны 10 дугаар сард болсон 9 дэхь ээлжийн яриа хэлэлцээ дуустал хоёр тал “гурван саад бэрхшээл”-ийг, өөрөөр хэлбэл: Хятад-Зөвлөлтийн хилийн бүс болон БНМАУ-аас зөвлөлтийн цэргийг гаргах, Афганистанаас зөвлөлтийн цэргийг гаргах, мөн Кампучиэс цэргээ гаргахыг Вьетнамд ятгаж зөвшөөрүүлэх гэсэн саадуудыг арилгах талаар тодорхой үр дүнд хүрч чадаагүй л байв. Гэвч Хятадын судлаач Кун Сайбин бичсэнээр зөвлөлдөх уулзалт үргэлжилж, хоёр талын яриа хэлэлцээний суваг оршиж, хятад-зөвлөлтийн харилцааг урагшлуулахад тодорхой үүрэг гүйцэтгэж байв.

Хүснэгт

Зөвлөлт-Хятадын 9 удаагийн яриа хэлэлцээ

Хэддэх удаа	Яриа хэлэлцээ болсон хугацаа	Болсон газар	Хятадын талын тэргүүн	Зөвлөлтийн талын тэргүүн
№1	1982.10.04-29	Бээжин	Цянь Цичэнь	Ильичев
№2	1982.2.27-3.15	Москва	Цянь Цичэнь	Ильичев
№3	1983.10.6-25	Бээжин	Цянь Цичэнь	Ильичев
№4	1984.3.12-26	Москва	Цянь Цичэнь	Ильичев
№5	1984.10.18-11.02	Бээжин	Цянь Цичэнь	Ильичев
№6	1985.04.09.-22	Москва	Цянь Цичэнь	Ильичев
№7	1985.10.04-05	Бээжин	Цянь Цичэнь	Ильичев
№8	1986.04.07-14	Москва	Цянь Цичэнь	Ильичев
№9	1986.10.07-10	Бээжин	Цянь Цичэнь	Игорь Рогачев

Эх сурвалж: Кун Сайбин. Зоучу Сулянь. Синьхуа чубаньшэ. Бэйцзин_ 2011. 386-р тал.

Хятад-Зөвлөлтийн харилцааг хэвийн болгох яриа хэлэлцээг хэрхэн мухардлаас гаргах вэ? Хятадын тал “гурван саад бэрхшээл”-ийг арилгах нь хоёр орны харилцааг үндсээр нь сайжруулах үндэс суурь гэж үзэж байсан бол ЗХУ-ын Л.И. Брежнев, Ю.В. Андропов, К.У. Черненко нарын гурван удирдагч аль аль нь үүнээс зайлсхийж, “гурван саад”-ыг тойрч, түүнээс аль болох зай барьж, харин эдийн

² Цянь Цичэнь. Хятадын дипломатын 10 том үйл явдлын тэмдэглэл. УБ., 2016. 45-р тал.

засаг-худалдааг хөгжүүлж, харилцан солилцоог нэмэгдүүлэх замаар хоёр орны харилцааг хэвийн болгож болно гэж үзэж байв. Михаил Горбачев ч анх гарч ирсэн даруйдаа “гурван саад бэрхшээл”-ийг арилгах талаар ямарваа нэг доривтой алхам хийх бодолгүй байв. Судлаач Д. Баярхүү бичсэнээр Зөвлөлт-Хятад хоёр хэзээ ч эвлэрэхгүй хэмээн баг итгэсээр Монголын удирдагч Ю. Цэдэнбал улс төрийн тавцнаас явж одсон бол Зөвлөлт-Хятад эвлэрвэл бид яах гэдэг ацан шалаатай Ж. Батмөнх тулгарчээ.³

1985 оны 10 дугаар сарын 9-нд Дэн Сяопин Румыны удирдагч Н. Чаушескутай уулзах үеэр Хятад-Зөвлөлтийн харилцааг хэвийн болгохын тулд “гурван саад бэрхшээл”-ийг арилгах, юуны өмнө Вьетнам Кампучиэс цэргээ гаргахаас эхлэх ёстой. Хэрвээ үүнийг шийдэж чадвал бусад асуудлыг шийдэхэд тийм ч хүнд биш. Хятад-Зөвлөлтийн харилцааг мухардлаас гаргахын тулд Дэн Сяопин Хятад-Зөвлөлтийн дээд хэмжээний уулзалтыг хийх саналыг анх дэвшүүлж, Чаушескуг энэхүү саналыг нь Горбачевт дамжуулж өгөхийг хүссэн юм. Хэрвээ зөвлөлтийн тал бидний саналыг хүлээн авч Вьетнамын цэргийг Кампучиэс гаргуулахаар болох аваас Дэн Горбачевтай уулзахад бэлэн гэв. Мөн Дэн хэдийгээр түүний гадагш айлчлах түүхэн үүрэг гүйцсэн боловч энэ асуудлыг шийдэхийн тулд гадагшаа явахад ч бэлэн байна гэв.⁴

Зөвлөлтийн тал энэхүү илгээлтийг хүлээн авснаа 1985 оны 11 дүгээр сарын 6-нд хариу мэдэгдэв. Мөн сарын 23-ны өдөр Зөвлөлтийн тал Зөвлөлт-Хятадын дээд хэмжээний уулзалтыг хийж, нам хоорондын харилцааг сэргээх цаг болсон гэж үзэж байна, хоёр орны удирдагч нарын уулзалтыг ЗХУ-ын Алс Дорнод эсвэл Хятадын нутагт хийж хоёр орны харилцааг хэвийн болгох асуудлыг хэлэлцэх хариу санал тавив.

М. Горбачев 1986 оны 7 дугаар сарын 28-нд Владивостокт үг хэлж Хятадтай сайн хөршийн харилцааг тогтоох “цаашдын алхамууд”-ын талаар чин сэтгэлээс ярихын тулд хэзээ ч ямар ч түвшинд хэлэлцэхэд бэлэн байна гэв. Тэрээр мөн ондоо багтаан Афганистанаас зөвлөлтийн 6 дивизийг татан гаргана, зөвлөлтийн цэргийг тэндээс бүрэн гаргах асуудал гаднын оролцоо үргэлжлэх эсэхээс хамаарна, түүнчлэн Монголын нутгаас Зөвлөлтийн “үлэмж цэрэг”-ийг гаргах асуудлаар монголын талтай ярьж байна гэв. Зөвлөлт-Хятадын хилийн дагуу байрлаж буй цэргийг хорогдуулах асуудлаар Хятадын талтай яриа хэлэлцээ хийх сонирхлоо мөн илэрхийлэв. Горбачев мөн Кампучийн асуудлыг хөндөж, энэ асуудал нь Хятад-Вьетнамын хоорондын асуудал бөгөөд Хятад-Вьетнамын харилцаа хэвийн болохоос хамаарна, Хятад, Вьетнам яриа хэлэлцээгээ сэргээж, тайван замаар хэлэлцэн тохирохыг л Зөвлөлтийн тал хүсэж байна гэж мэдэгдэв.⁵

“Гурван саад бэрхшээл”-тэй холбоотой асуудлаар “урьдчилсан болзлыг хүлээн авахгүй”, “гуравдахь орны эрх ашгийг хөндөхгүй”, “Хятадад хэзээ ч

³ Д. Баярхүү. Жамбын Батмөнх. НЭПКО, УБ., 2015. 236-237-р тал.

⁴ М.С. Капица. На разных параллелях: Записки дипломата. М., 1996. с. 114.

⁵ М.С. Капица. Указ. Книга. с. 116-117.

заналхийлээгүй” зэрэг хэвшсэн хэллэгийг хэрэглээгүй, Афганистан, Монгол, Зөвлөлт-Хятадын хил орчмын бүсээс цэрэг гаргах асуудлаас тойрч зайлсхийгээгүй зэрэг уян хатан зүйл Горбачевын хэлсэн үгэнд туссан байв. Вьетнам, Кампучийн асуудлаар ч аядуу үг хэллэг хэрэглэж, одоо асуудлыг шийдэх таатай үе гэжээ.

Дэн Сяопин 1986 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр америкийн сэтгүүлч Mike Wallace –д телевизийн ярилцлага өгөхдөө Хятад-Зөвлөлтийн харилцааны асуудлыг хөндөв. Тэрээр Горбачевын ярилцлагад зарим нэг шинэ зүйл байгаа учраас бид болгоомжтойгоор талархан хүлээж авч байгаа юм. Вьетнамын цэргийг Кампучиэс гаргах нь Хятад-Зөвлөлтийн харилцааг хэвийн болгох зангилаа асуудал гэдгийг онцлоод хэрвээ Горбачев Кампучийн асуудлыг шийдэх чиглэлд тодорхой алхам хийх аваас Дэн Сяопин Зөвлөлтийн нутагт хаана ч хамаагүй очиж Горбачевтай уулзалт хийхэд бэлэн байна гэв. 1986 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр хятадын тал Дэн Сяопины энэхүү ярилцлагыг нийтэлж, дэлхий дахинд цацсан бөгөөд энэ нь нэг ёсны Горбачевын Владивостокт хэлсэн үгэнд барьсан хятадын талын албан ёсны хариу байв.⁶

2. Дээд хэмжээний уулзалтын тухай

Хятад-Зөвлөлтийн удирдагчдын дээд хэмжээний уулзалт нь дэлхий нийтийн анхаарлыг татсан нэн чухал үйл явдал байв. “Нью Йорк Таймс” сонин Хятадын удирдагч 84 настай Дэн Сяопин, ЗХУ-ын удирдагч 58 настай М.С. Горбачев нар Бээжинд уулзаж, гар барьснаар “Хятад болон ЗХУ-ын хооронд 30 жил үргэлжилсэн дайсагналцлыг албан ёсоор төгсгөл болж буй”-г дэлхий дахинд зарлалаа” гэж бичжээ.⁷ М. Горбачевыг хүлээн авах ёслолын ажиллагааг хэлэлцэх үеэр нөхөр Дэн Сяопин ёслолыг зохих түвшинд хийх, мөн “хоёр удирдагч тэврэлдэх шаардлагагүй, гар барих нь зохистой” гэсэн зааврыг Хятадын ГЯЯ-ны ёслолын хэлтэст өгчээ. Энэхүү 6 ханзаас бүтсэн заавар нь зөвхөн ёслолын хэм хэмжээг заасан төдийгүй тухайн үеийн Хятад-Зөвлөлтийн харилцааны шинж чанарыг илтгэж байснаас гадна хоёр орны ирээдүйн харилцааны хандлагыг ч тодорхойлж өгсөн байна.

Америкийн судлаач Жон Гарвер “ЗХУ-ын удирдагч М. Горбачевын айлчлалаар хоёр тал цаашид “шинэ хэлбэрийн, хэвийн, тогтвортой, сайн хөршийн, нөхөрсөг” гэсэн тодотголтой Зөвлөлт-Хятадын харилцааг хөгжүүлэхээр ярьж тохирчээ. Горбачев болон Дэн Сяопин нар уулзсанаар “төр засаг” хоорондын харилцааг хэвийн болгосон бол Горбачев болон ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Жао Зыян нар уулзсанаар ЗХУКН, ХКН хоорондын эрх баригч намын харилцаа хэвийн боллоо гэж зарлав. Дээд хэмжээний уулзалт нь Бээжингийн төвд орших Тяньаньмэний талбайд оюутан залуусын “ардчиллын төлөө” олон хоногийн жагсаал цуглаан ид өрнөж байсан цаг үед болж өнгөрөв. Жагсаал цуглаанаас

⁶ Deng Xiaoping. “Interview with Mike Wallace of 60 minutes”, Sept. 2, 1986. Published by USC US-China Institute, <http://china.usc.edu>

⁷ New York Times, 16 May 1989.

болж Горбачевыг дагалдан ирэх 1000 хүнийг 300 болгож, олон арван арга хэмжээг цуцалж, эсвэл өөр газар нүүлгэн хийсэн зэрэг нь ХКН-ын удирдагчид хүндэт зочны өмнө “ёс алдсан” /loss of face/ ичгүүртэй протоколын арга хэмжээ боллоо. Гэвч дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн гол анхаарал оюутан залуусын жагсаал цуглаанд төвлөрсөн байсан тул Зөвлөлт-Хятадын дээд хэмжээний уулзалт хоёрдугаар зэргийн асуудал болж өнгөрчээ” гэж АНУ-ын судлаач бичсэн байна.⁸ Дэн Сяопин дээд хэмжээний уулзалтын үзэл санааг дөрөвхөн хятад ханз үсгээр “Өнгөрсөнд цэг тавьж, ирээдүйг нээх” хэмээн тодорхойлсон нь тун нарийн утга учиртай үг байв.

1989 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 10 цагаас 12 цаг 30 минутын хооронд Дэн Сяопин Михаил Горбачевтай Ардын их хурлын ордны зүүн танхимд 2 цаг 30 минут түүхэн уулзалт хийсэн юм. Тэр өдөр Дэн Сяопин нэн жавхаатай, цовоо сэргэлэн харагдаж байв. Тэрээр маш ой сайтай байсан учир яриа хэлэлцээг хийх үед бэлтгэсэн цаас ашигладаггүй байв. Түүний үг яруу тод, голчоо олсон, логик уялдаа сайтай байдаг байсныг хятадын судлаачид тэмдэглэжээ. Тэрээр юуны өмнө Хятадын түүхээс хоёр асуудлыг чухалчилсан ажээ. Нэгд, сүүлийн 100 жилд Хятад улс их гүрнүүдийн дарлалаас хүлээсэн гай зовлон, хоёрт, сүүлийн хэдэн 10 жилд Хятадад заналхийлсэн хамгийн ноцтой аюул занал хаанаас ирсэн тухай байв. Дэн Сяопин Хятад-Зөвлөлтийн харилцааны гэрэлтэй, сүүдэртэй талыг базан дүгнээд ЗХУ нь Хятадыг өөрийн тэгш эрхтэй түнш хэмээн үзээгүйгээс бүхий л зарчмын алдаа үүссэн гэж үздэгээ хэлэв. Тэрээр мөн ЗХУ шинэ Хятадын үүсэн байгуулагдсан анхны жилүүдэд аж үйлдвэрийн үндэс суурийг бий болгох үйлсэд өгөөмөр тус хүргэснийг хятадын тал хэзээ ч мартахгүй гэдгийг нотлов. Хоёр талын үзэл суртлын маргааны тухайд Дэн өөрөө тэр маргаанд биечлэн оролцож байсны хувьд хоёр талын гаргаж байсан нотолгоонууд нь хоосон үг байсан гэж үздэгээ хэлэв. Тэрээр “бидний хятадуудын үзэл бодол ч тэр болгон зөв байсан гэдэгт би итгэдэггүй” гэв. Өнгөрснийг ярих учир нь урагш харахын тулд ярьж байгааг тэрээр онцлов. Утга учиргүй маргах нь өнгөрсний асуудал, одоо урагшаа ирээдүйгээ харж явах нь чухал гэдгийг тэрээр онцлов.⁹

“Известия” сонин 1989 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн дугаартаа Горбачев-Дэн Сяопин нарын уулзалтын тухай дэлгэрэнгүй мэдээлсэн билээ. Горбачев ч Орос, ЗХУ, Хятадын харилцаа хэрхэн үүсэж хөгжсөн тухайд зөвлөлтийн тал өөрийн гэсэн үзэл бодол байр суурьтай. Хэдий тийм ч Хятад-Зөвлөлтийн харилцааны тийм ч холын бус үед ЗХУ зарим алдаа гаргасан, зөрчил хагаралд ч өөрийн гэсэн хариуцлага үүрэх ёстой гэв. Тэрээр өнгөрсөн үеийн маргаанд бүрэн цэг тавих нь зүйтэй гэдэгтэй санал нэг байв.¹⁰ Тэрээр Дэнтай хийх яриа хэлэлцээнд сайтар бэлтгэж ирсэн нь тодорхой. Хятадад сууж байсан ЗХУ-ын элчин сайд Олег Трояновский өөрийн дурсамжид Горбачев 84 настай Дэн Сяопинтай ярихдаа ахмад үеийн хүнтэй түүнээс залуу үеийн хүн ярьдаг журмаар ярина гэж

⁸ John W.Garver. The “New Type” of Sino-Soviet Relations. Asian Survey.Vol. 29,No 12 (Dec 1989), pp. 1136-1137.

⁹ Кун Сайбин. Зоучу Сулянь. Синьхуа чубаньшэ. Бэйцзин, 2011. 403-406-р тал.

¹⁰ “Известия”, 1989.05.16.

ойр тойрныхондоо хэлж байсныг дурсан бичсэн байдаг.

“Известия” сонин мөн Горбачев-Дэн нарын уулзалтын явцад Орос-Хятадын болон Зөвлөлт-Хятадын харилцааны түүхийн зарим асуудлууд яригдлаа гэж бичсэн байдаг. Түүхийн ямар асуудлууд яригдсан юм болоо? Тэгвэл 1993 онд Бээжинд хэвлэгдсэн “Дэн Сяопины түүвэр зохиол /1982-1992/” хэмээх III ботид тухайн уулзалтын үеэр Дэн Сяопинаас Горбачевт ярьсан түүхийн асуудлуудыг тодорхой бичжээ. Түүнийг сийрүүлбэл:

Дэн Сяопин: Бидний уулзалтын зорилго бол өнгөрснийг ард орхиж, шинэ эрин үеийг нээх явдал болно. Өнгөрснийг ард орхисноор тэр тухай ярихаа зогсож, ирээдүйд анхаарлаа төвлөрүүлбэ гэсэн санаа. Гэвч өнгөрсөн тухай дуугүй өнгөрч болохгүй. Бид үзэл бодлоо Танд ойлгуулах хэрэгтэй. Хятадын ард түмэн, Хятадын Коммунист нам өнгөрсний тухай юу гэж боддогийг би Танд хэлэх ёстой. Та заавал үүнд хариулах, маргах гэх хэрэггүй. Би хоёр зүйлийг товч ярья. **Нэгд**, Хятад чөлөөлөгдөхөөс өмнө их гүрнүүдийн дарлал мөлжлөгөөс хэрхэн зовж зүдэрсэн бэ? **Хоёрт**, орчмын үед, ялангуяа сүүлийн 30 жилд хаанаас аюул гарч байна гэж Хятад харж байв? Эхний асуудлаар: Хар тамхины дайнаас эхлэн Чин улсын авлигач бодлогоос болж Хятад гадаад орнуудын түрэмгийлэл, боолчлолд өртөж, хагас колони, хагас феодалын орон болсон. Нийтдээ 10 гаруй орон, ялангуяа Их Британи оройлон Хятадыг дарамтласан. Хятадаас хамгийн их ашиг хонжоо олсон нь Япон, хаант Орос хоёр болно. ЗХУ ч зарим цаг үед, зарим асуудлаар ашиг хонжоо хайсан.

Дэн цааш нь: Япон үе үе манай орны үлэмж хэсгийг эзлэн түрэмгийлсэн. Тайванийг 50 жил эзлэж, Хятадад нөлөөний бүсээ тогтоосон. Умард Хятадад Японы олон концессын нутаг байсан. Япон 1931 онд Хятадын эсрэг түрэмгий дайн эхлүүлж, 1932 онд Зүүн Хойд Хятадад Манжгогийн дэглэм байгуулсан. 1937 онд бүрэн хэмжээний дайн эхлүүлж, 8 жил байлдсан. Хятадын эсэргүүцэл, фашизмын эсрэг холбоотон орнуудын хамтын тэмцэл, Зөвлөлтийн цэрэг Зүүн Хойд нутагт орж ирсний ачаар Япон эцэстээ бүрэн ялагдсан. Япон Хятадад асар их зовлон, хохирол учруулсан. Хятадууд хэдэн арван саяар үхэж үрэгдсэн. Хэрвээ бид түүхэн тооцоо бодох аваас Япон хамгийн их өртэй...

Дэн Сяопин үргэлжлүүлэн: Хятадаас асар их ашиг хонжоо хайсан өөр нэг орон бол хаант Орос, дараа нь ЗХУ байв. Хаант Орос эрх тэгш бус гэрээг нялзааж, 1,5 сая гаруй хав.дөр. км Хятадын газар нутгийг эзлэн авсан. Октябрийн хувьсгалын дараа ч Хятадад өнгөлзөж байлаа. Жишээ нь 1929 онд ЗХУ Хэйсяозы /Амур, Уссури мөрний арлууд: Ц.Б./ арлыг булаан авсан. АНУ, Их Британи, ЗХУ дэлхийн II дайн дуусахын өмнөхөн Ялтад нууц хэлэлцээр хийж, Хятадын эрх ашгийг хохироон нөлөөний бүсээ тогтоосон. Тэр үе бол Сталины үе байв. Тэр үед Гоминьданы Засгийн газар ЗХУ-тай гэрээ байгуулж, Ялтын хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн. БНХАУ байгуулагдсаны дараа бид ЗХУ-тай шинэ гэрээ байгуулсан. БНХАУ БНМАУ-тай дипломат харилцаа тогтоож, хоёр орны хилийн шугамын тухай тохиролцоонд хүрсэн. Хятад ЗХУ-тай ч хилийн асуудлаар хэлэлцээ хийж,

хаант Орос Чин гүрэнтэй байгуулсан гэрээнүүд тэгш бус байсан, Орос Хятадын нутгаас дээрэмдэн авсан түүхэн үнэнийг хүлээн зөвшөөрөхийг хүсч байсан. Ямар ч гэсэн тэдгээр гэрээ ёсоор 1,5 сая гаруй хав.дөр. км газар нутгийг булаан авсан байдаг. Энэ бол миний ярих гэсэн эхний асуудал.

Дэн Сяопин хоёрдугаар асуудлын тухайд: Сүүлийн хэдэн 10 жилд Хятадад хаанаас аюул заналхийлж байсан бэ? Дэлхийн II дайны дараахан Хятадад хувьсгал ялж, Ардын Бүгд Найрамдах улс байгуулагдсан. Хятад бусад оронд халдан довтлоогүй, тэдэнд аюул учруулаагүй. Харин бусад орон Хятадад заналхийлсэн. Манай орон ядуу, сул дорой боловч тусгаар тогтносон улс байсан. Хаанаас гол аюул ирж байв? БНХАУ байгуулагдсаны дараахнаас энэ асуудалтай тулгарсан. Тэр үед аюул АНУ-ын зүгээс ирж байв. 1960-аад оноос ЗХУ, Хятадтай хиллэх өөрийн болон Монголын хилийн бүсэд цэргээ байрлуулж зузаатгав. Пуужингийн тоо нь ЗХУ-ын бүх пуужингийн 1/3-д хүрч, байрлуулсан цэрэг нь Монголд байгааг оролцуулан 1 саяд хүрч байлаа. Хаанаас аюул ирэх болов? Хятад энэ байдалд дүгнэлт хийхээс өөр аргагүй байдалд орсон. 1963 онд би Хятадын төлөөлөгчдийг тэргүүлж Москвад очиж байв. Яриа хэлэлцээ тасалдсан. 1960-аад оны дундаас манай харилцаа асар муудаж, үндсэндээ бүрэн зогссон. Зөвхөн зөрүүтэй үзэл бодлын маргаанаас болсон гэж би бодохгүй байна. Бидний тэр үед хэлсэн болгон зөв байсан гэж би хэлэхгүй. Гол асуудал хятадуудыг эрх тэгш гэж үзээгүй, тэгээд ч бид доромжлуулсан гэж тооцож байв. Гэвч ЗХУ манай анхдугаар 5 жилийн төлөвлөгөөний жилүүдэд аж үйлдвэрийн үндэс суурийг тавьж өгснийг бид хэзээ ч мартаж учиргүй.

Дэн эцэст нь: Хэрвээ би эдгээр асуудлын тухай удаан ярьсан бол өнгөрснийг ардаа орхихын тулд ярьсан юм шүү. Зөвлөлт нөхөд өнгөрсний тухай бидний үзэл бодлыг ойлгож, тэр үед бид юу бодож байсныг мэдээсэй гэж хүссэн юм. Одоо бид нэгэнт түүхээ тоочсон тул түүнийг мартаж хэрэгтэй. Энэ бол өнөөдрийн бидний уулзалтын нэг гол үр дүн мөн. Одоо би хэлье гэсэн зүйлээ хэлчлээ. Үүгээр төгсгөл болог. Өнгөрсөн бол өнгөрсөн гэжээ.¹¹

Дэн Сяопины ийнхүү түүх сөхөж ярьсан нь санамсаргүй зүйл биш гэдэг нь ойлгомжтой. Тэрбээр олон арван жил сэтгэл санаандаа тээж явсан Мао Зэдун, Дэн Сяопин, Жоу Эньлай нарын ХКН, Хятадын ахмад үеийнхэн Хятад-Хаант Орос, Хятад-ЗХУ-ын харилцааны түүхийг хэрхэн үздэг тухай нэг ёсны “түүхийн ой санамж” /Historical memory/ -аа ЗХУ-ын харьцангуй залуу 58 настай шинэ үеийн удирдагч М.С.Горбачевт хэлж ойлгуулж, одоо ингээд өнгөрсөнд цэг тавьж, ирээдүйд шилжье гэсэн түүхэн алхам хийжээ. Дэн Сяопины ярьж буй 1, 5 сая хав. дөр.км нутаг бол Хятадын талын нотолдогоор хаант Орос манж Чин гүрэнд Нэрчүү, Буурын зэрэг эрх тэгш бус гэрээг тулган нялзааж, одоогийн Байгал нуураас зүүн тийших нутаг, одоогийн Владивосток, Хабаровск, Камчаткийн нутгийг Хятадаас булаан авсан гэж үздэгийг хэлжээ. Өөрөөр хэлбэл, одоогийн ОХУ-ын Алс Дорнод,

¹¹ Дэн Сяопин вэнсюань. \Дэн Сяопины түүвэр зохиол\ 3-р боть. “Жэньминь” хэвлэлийн газар. Бээжин, 1993, 291-295-р тал.

Приморье мужийн зарим нутгийг хэлж байна.

Харин Дэн Сяопин БНМАУ-ын газар нутгийн тухайд тун болгоомжтой, битүү байдлаар ярьжээ. Дэнгийн “Түүвэр зохиол”-д “АНУ, Их Британи, ЗХУ дэлхийн II дайн дуусахын өмнөхөн Ялтад нууц хэлэлцээр хийж, Хятадын эрх ашгийг хохироон нөлөөний бүсээ тогтоосон. Тэр үе бол Сталины үе байв. Тэр үед Гоминьданы Засгийн газар ЗХУ-тай гэрээ байгуулж, Ялтын хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн. БНХАУ байгуулагдсаны дараа бид ЗХУ-тай шинэ гэрээ байгуулсан. БНХАУ БНМАУ-тай дипломат харилцаа тогтоож, хоёр орны хилийн шугамын тухай тохиролцоонд хүрсэн” гэжээ. Өөрөөр хэлбэл, Ялтын нууц хэлэлцээрээр Хятадын эрх ашгийг хохироосон, гэвч Гоминьданы Засгийн газар үүнийг хүлээн зөвшөөрсөн. Харин 1949 оны хувьсгалын дараа БНХАУ ЗХУ-тай шинэ гэрээ байгуулсан, БНМАУ-тай дипломат харилцааг тогтоож, түүнтэй хилийн шугамаа тохирсон гэдгийг ярьжээ.

Дэнгийн “Түүвэр зохиол”-д ороогүй нэг чухал зүйл М.С. Горбачевын Москвад 1995 онд хэвлэгдсэн “Жизнь и Реформы” номонд орсон байна. Энэ хэсэгт Дэн Сяопин: “1954 онд Н.Хрущев тэргүүтэй, Булганин, Микоян нар багтсан ЗХУ-ын төлөөлөгчид Хятадад ирэх үеэр Хятадын тал тэднээс “Монголын асуудлыг шийдэх цаг болсон юм биш үү?” гэсэн асуулт тавьсан. Хрущев энэ тухай Монголын нөхөдтэй ярих нь зүйтэй болов уу гэсэн хариулт өгч байв. Бид үүнийг Зөвлөлтийн нөхдийн хариулт нь практик дээр асуудлыг шийдэхээс татгалзаж байна гэж ойлгосон. Тийм байдлаар 1,5 сая хав.дөр.км нутагтай Гадаад Монгол буюу БНМАУ-ыг Хятадаас салгаж авсан юм”¹² гэж ярьжээ.

Хэдийгээр Дэн Сяопин энэ бүхнийг “түүхийн асуудалд цэг тавих гэсэн юм, энэ хэрэг явдал салхинд хийсэн алга болог, бид санаа бодлоо л илэрхийлсэн юм” гэх зэргээр булзааруулсан боловч БНМАУ-ын газар нутгийн тухайд 84 настай Дэн Сяопин өөрийн үеийн Хятадын хувьсгалчдын үзэл бодлыг илэрхийлжээ гэж үзэхээс өөр аргагүй.

Зөвлөлтийн дипломатч, эрдэмтэн М.С. Капица Зөвлөлт-Хятадын харилцааг хэвийн болгосон Горбачевын айлчлал 1989 оны 5 дугаар сард болсон боловч цаг хугацааны хувьд нэн тохиромжгүй үед болсон гэжээ. Яг тэр үед Бээжинд хятадын оюутнуудын жагсаал үймээн болж байсан учраас Горбачевын айлчлал оюутнуудын жагсаалд “гал нэмэх” аюултай байв. Горбачев Ян Шанкүнь, Дэн Сяопин, Жао Зыян нартай тус бүрчлэн уулзаж, төрийн хүлээн авалтанд оролцож, хамтарсан коммюнике гаргаснаар айлчлал шуурхай болов. Хоёр тал нам хоорондын харилцааг оролцуулан хоёр орны харилцааг хэвийн болсныг зарлаж, хилийн бүсэд цэрэг хорогдуулах, түүний тулд тусгай механизм бий болгох, Кампучийн асуудлаар санал зөрж байсан боловч бүс нутгийн мөргөлдөөнийг зохицуулахын төлөө гэдгээ нотлов. Хамгийн гол үр дүн нь энх тайвнаар зэрэгцэн орших зарчмууд дээр тулгуурласан сайн хөршийн, тэгш эрхтэй хамтын ажиллагаа гэсэн шинэ харилцааны зарчмын үндэс

¹² М.Горбачев. Жизнь и реформы. Книга 2. Москва, 1995, с. 435-440.

суурийг тавьж өгөв. Хятад нөхдийн хэлснээр хятад-зөвлөлтийн харилцаа 1950-иад оных шиг болохгүй, түүнчлэн 1960-70-аад оны эсрэг тэсрэг зөрчилдөөнийг ч давтах ёсгүй гэж тохиров гэжээ.¹³¹³

“Ирээдүйг нээнэ” гэсэн хоёр талын тодорхойлолт нь Хятад-Зөвлөлтийн харилцааг хэвийн болгосны дараах хоёр орны харилцааны зарчим, хоёр орны шинэ маягийн харилцааны цаашдын чиг хандлага, нэг ёсны тоглоомын дүрмийг зааж өгсөн юм. Дэн Сяопин олон улсын коммунист хөдөлгөөний түүхэн сургамжийг дүгнээд холбоостон болох, мөргөлдөж сөргөлдөх аль аль нь эцсийн дүндээ амжилтгүй болдогийг онцлоод, Хятад-Зөвлөлтийн харилцаа “энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим” дээр тулгуурлах ёстойг тэмдэглэв. Горбачев хэвлэлийн бага хурал дээр тэрбээр Дэн болон Хятадын бусад удирдагчидтай ярилцаад “Хятад-Зөвлөлтийн дээд хэмжээний уулзалт нь хоёр орны харилцаа шинэ шатанд гарсныг илтгэн харууллаа. Хоёр орны харилцаа цаашид улс орны хоорондын түгээмэл тогтсон хэм хэмжээнд, энх тайвнаар зэрэгцэн орших зарчимд тулгуурлах болно. Хятад-Зөвлөлтийн харилцаа аль нэг гуравдахь оронд чиглээгүй, аль нэг гуравдахь орны эрх ашгийг хохирооход чиглээгүй гэдгийг бид онцлож байна. Манай харилцаа нь өнөөгийн дэлхий дахины хөгжил хандлагатай нягт уялдах болно” гэж мэдэгдсэн.

Дээд хэмжээний уулзалтын дараа гаргасан хамтарсан мэдэгдэл Хятад-Зөвлөлтийн харилцааны зарчмыг тодорхойлж өгсөн юм. 1950-иад оны ах дүүгийн холбооноос өөр, 1960, 1970-аад оны сөргөлдөөнөөс өөр цоо шинэ маягийн харилцаа тавигдсан билээ. Энэхүү харилцаа нь холбоотны ч биш, сөргөлдөгч талуудын ч биш, гуравдахь орны эсрэг ч чиглэсэн биш гэж хоёр тал мэдэгдэв. Энэхүү харилцаа нь найрсаг хөрш орнуудын харилцаа байх болно. Ийм шинэ харилцаа нь хоёр орны ард түмний эрх ашигт нийцэх төдийгүй дэлхийн энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалахад ч тустайг цаашдын үйл явдал гэрчилсэн билээ.

Америкийн нэрт нанхиадач Х. Киссинжер “Горбачев Тянаньмэний хямралын эхэн үеэр Бээжинд айлчилж таарав. Горбачевын байдал Бээжингийнхнээс илүү төвөгтэй байлаа. Хятадууд коммунист нам хэрхэн засаг барих вэ гэдэгтээ толгой гашилгаж байв. Харин Зөвлөлтийнхний хувьд коммунист нам ер нь засаг барих хэрэгтэй юм уу гэдэгт асуудал тулаад байлаа. Горбачев эдийн засгийн өөрчлөлт буюу перестройка-даа биш харин улс төрийн шинэчлэл гласность-даа илүү ач холбогдол өгснөөс болж коммунист засаглалын хууль ёсны эрхийг бүрх асуудалтай болгосон билээ” гэж дүгнэжээ. Хятад нөхөд улс төрийн реформ яваандаа хэрэгтэй байж болох юм, гэвч эдийн засгийн реформ түүнээс заавал түрүүлж явах ёстой гэж үзэж байсныг Киссинжер цохон тэмдэглэжээ.¹⁴¹⁴

Америкийн хятад судлаач Жон Гарвер Хятад, Зөвлөлт энэхүү Зөвлөлт-Хятадын харилцааг хэвийн болгосноор тус тус ямар ашиг хожоо олно гэж тооцож байсныг дараах байдлаар дүгнэжээ. Тэрбээр “Хятад ЗХУ-тай харилцаагаа сайжруулснаар хэд хэдэн хожоо гарч ирнэ гэж тооцож байв. Юуны өмнө намжмал байдал Хятадын

¹³ М.С. Капица. На разных параллелях: Записки дипломата. М., 1996. с. 118.

¹⁴ Henry Kissinger. On China. The Penguin press. New York. 2011. pp. 456-458.

батлан хамгаалах төсвийн ачааллыг багасгаж, эдийн засгийн хөгжил, 4 шинэчлэлдээ илүү их нөөцөө шилжүүлэх боломж олгоно гэж найдаж байлаа. Москвад ч мөн Бээжинтэй ойртох нь хожоотой байв. Горбачев ч нөөц баялагаа батлан хамгаалахаас эдийн засагт шилжүүлэх, нэн ялангуяа Сибирийг өөд татах, хөгжүүлэхэд Хятад, Япон, Өмнөд Солонгос, Тайваний бизнес оролцоог хангах үүдийг нээж өгөхөөр тооцож байлаа. Зөвлөлт-Хятадын харилцааг эрс сайжруулснаар 1980-аад оны эхээс Зөвлөлтийг зовоож ирсэн Хятад-Өрнөдийн альянс холбоо байгуулагдах боломжийг хаана гэж Москва үзэж байлаа” гэж бичиж байв.¹⁵¹⁵

Зөвлөлт-Хятадын харилцаа хэвийн болох нь Хятад-Америкийн харилцаанд хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг Вашингтонд анхааралтай ажиглаж байв. Жон Гарвер өгүүлэлдээ “1972 оноос хойш 20 орчим жилийн турш Хятад-Америкийн харилцааг түшиж ирсэн гол багана нь “жанжлалын эсрэг” /anti-hegemony/ зарчим дээр суурилсан Зөвлөлтийн эсрэг нэгдсэн фронт байв. Горбачев-Дэн Сяопин нарын хамтарсан мэдэгдэлд ЗХУ, Хятад аль аль нь тус бүс нутагт жанжлалыг тогтоохыг эрмэлзэхгүй гэсэн заалт оржээ. Ингэснээр АНУ-Хятадын “anti-hegemony” зарчим утга учираа алдав. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Фрэнк Карлуччи 1988 оны 9 дүгээр сард Хятадад айлчлах үеэр хоёр тал энэ зарчмын тухай харилцан ойлголцолд хүрсэн бололтой. Тиймээс ч Хятадын тэнгисийн цэргийн Жэн Хэ усан онгоц 1989 оны 4 дүгээр сард Пёрл Харбор боомтод зочилж, АНУ-ын 3 усан онгоцоос бүрдсэн эскадрон Горбачевын айлчлалын дараахан Шанхайн боомтод анх удаа зочлов. Бээжин мөн Вашингтонд хандан Зөвлөлт-Хятадын харилцаа хэзээ ч бүр дотносохгүй, ялангуяа 1950-аад оных шиг “холбоотны” харилцаанд хэзээ ч эргэж очихгүй гэв. Коммюникед “Зөвлөлт-Хятадын найрамдалт харилцаа гуравдагч этгээдийн эсрэг чиглээгүй, гуравдагч этгээдийн эрх ашигт харшлахгүй” гэж ил тод мэдэгдэв” гэжээ.¹⁶¹⁶ Хэдийгээр Бээжин Зөвлөлтийн эсрэг АНУ-тай тогтоосон “жанжлалын эсрэг холбоо” сүлбээгээ эцэс болгож буй боловч АНУ-тай батлан хамгаалах салбарт харилцаагаа үргэлжлүүлнэ гэсэн тохиролцоонд хүрсэн байсан бололтой.

ДҮГНЭЛТ

М.Горбачев, Дэн Сяопин нарын Бээжинд хийсэн түүхэн уулзалт Монголын тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдалд ямар нөлөө үзүүлсэн бэ? гэсэн асуулт тавигдаж байна. Горбачевын Хятадад хийх айлчлал эхэлсэн 1989 оны 5 дугаар сарын 15-ны өдөр бас нэг түүхэн үйл явдалтай давхцсан билээ. Тэр өдөр “Ассошиатэд Пресс” агентлаг Москвагаас “Өнөөдөр Горбачев Бээжинд ирж байх тэр мөчид Хятадтай хиллэх Монголын газар нутгаас Зөвлөлтийн танк, их буу олон мянгаар гарч эхэллээ” гэж дэлхий даяар мэдээлж байлаа. Зөвлөлтийн генерал Юрий Маркелов тус агентлагт энэ гарч буй зэвсэг техник нь Зөвлөлтийн цэргийг Монголоос гаргах хоёрдахь ээлжийн ажил эхэлж буй бөгөөд

¹⁵ John W.Garver. The “New Type” of Sino-Soviet Relations. Asian Survey.Vol. 29.No 12 (Dec 1989), pp. 1141-1142.

¹⁶ Ibid., pp. 1143-1144.

тэнд буй нийт цэргийн 75 хувь буюу 50000 цэргийг 2 жилийн хугацаанд гаргах болно гэж мэдэгдэж байв.¹⁷

Судлаач Д. Баярхүү “Жамбын Батмөнх” номондоо бичсэнээр ЗХУ-ын ГЯЯ-ны орлогч сайд И. Рогачев 1989 оны эхээр Монголд ирж хэлэлцэн тохиролцсоны дагуу 1989 онд БНМАУ-ын Засгийн газартай тохиролцсоны дагуу Монгол дахь Зөвлөлтийн цэргийн бүлгээс бие бүрэлдэхүүний тоо 50320 хүнээр хасагдаж, 3118 танк, 768 их буу, 351 байлдааны нисэх онгоцыг эхлэн гаргажээ”.¹⁸

ЗХУКН-ын Төв Хорооны Улс Төрийн товчоо 1989 оны 12 дугаар сард БНМАУ-аас цэргээ бүрмөсөн гаргах эцсийн шийдээ гаргаж, 1992 оны сүүлчээр Зөвлөлтийн цэрэг Монголын нутгаас бүрмөсөн гарч, Зөвлөлт-Хятадын харилцааны Монголыг тойрсон нэгэн түүхэн зөрчил маргаан шийдэгдсэн билээ. Түүхч, судлаач Т.Төмөрхүлэг 1989 оны Зөвлөлт-Хятадын хамтарсан мэдэгдэлд орсон нэгэн заалтын ач холбогдлыг цохон тэмдэглэжээ. ЗХУ, БНХАУ-ын хамтарсан мэдэгдлийн Ү зүйлд “хил залгаа гуравдахь орнуудын газар нутаг, гол мөрөн, нуур цөөрөм хийгээд агаар мандлыг ашиглах аргаар ч гэсэн бие биедээ хүч хэрэглэх юм уу аль нэг хэлбэрээр мөчөөрхөхгүй, маргаантай бүхий л асуудлаа эв зүйгээр зохицуулна” гэдгээ нотолсон нь Монголтой шууд хамааралтай гэж үзжээ. Т.Төмөрхүлэг “Уул баримт бичигт гуравдахь орнуудын талаар тусгасан зүйл чухамдаа коммунист хоёр их гүрний гучаад жил эвдрэлцээд сая нэг эвлэрсний нэгэн зүйл тайлал бүлгээ. Монголыг цэрэг-дайны талбар болгох гэх санаа тус орны тусгаар тогтнон оршихтой холбогдсон нэн эмзэг асуудал байсаар ч ирсэн, байх ч болно. Монголын талаар ямар бодлого баримтлахыг хэн ч энэ хоёр улсад тулгахгүй, тэд үүнийгээ хэнээр ч заалгахгүй нь үнэнтэй боловч 1989 оны баримт бичигтээ Монголд ээлтэй заалт тусгасан нь түүхийн хувьд олзуурхууштай хэрэг болов” гэж бичжээ.¹⁹

Зөвлөлт-Хятадын харилцаа бүрэн хэвийн болсон нь ямарваа нэг гуравдагч орны эсрэг чиглээгүй, гуравдагч орны эрх ашигт харшлахгүй хэмээн ЗХУ, БНХАУ-ын удирдагчид дээд хэмжээнд мэдэгдсэн нь АНУ, Энэтхэг, Вьетнам зэрэг орнуудад шууд хандсан боловч Монголд мөн л дам хэлбэрээр хандсан гэж үзэж болно. Түүнчлэн Зөвлөлт-Хятадын харилцаа 1950-аад оных шиг холбоотны харилцаанд эргэж очихгүй хэмээн хариуцлагатай мэдэгдсэн нь хөрш хоёр их гүрэн хавсайдан Монголын эрх ашгийг хохироохгүй гэсэн амлалт гэж бас ойлгож болно. Оросын тал “хилийг цэрэггүй бүс болгох хоёр талын механизмыг бий болгосноор ЗХУ болон БНХАУ-ын хиллэдэг газар нутгийг энх тайван, ажил хэрэгч хамтын ажиллагааны бүс нутаг болгон хувиргахад чиглэх ёстой” гэж бичиж байв.²⁰ Ийнхүү 1986 онд Владивостокт Горбачевын эхлүүлсэн Зөвлөлт-Хятад, Монгол-Хятадын хилийн бүсэд төвлөрсөн цэргийг татан гаргах, аажмаар цэрэггүй бүс болгох үйл явц хэрэгжих шатандаа оров.

¹⁷ Associated Press, Moscow, May 15, 1989.

¹⁸ Д.Баярхүү. Жамбын Батмөнх. 241-242-р тал.

¹⁹ Т.Төмөрхүлэг. Орос, Монгол, Хятад: Улс төр, дипломатын харилцаа \1949-1990\ УБ. 2016. 265-р тал.

²⁰ Подведена черта под прошлым-открыт путь в будущее. Проблемы Дальнего Востока, 1989, № 3, с. 3-6.

Дэн Сяопины “өнгөрсөнд цэг тавьж, ирээдүйг нээе” гэсэн томъёолол нь Монгол-Хятадын харилцаанд 1989 оны эхээр Горбачевын Бээжинд хийх айлчлалаас хоёр сарын өмнө бүрэн тусгалаа олсон билээ. БНХАУ-ын дарга Ян Шанкүнь БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Ц. Гомбосүрэнг 1989 оны 3 дугаар сард Бээжинд хүлээн авч уулзахдаа хоёр орны харилцааны өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн тухай богино боловч гүн гүнзгий утгатай үг хэлжээ. Тэрбээр “...Өнгөрсөн хэсэг хугацаанд хоёр орны хооронд зарим “түвэгтэй асуудал” байлаа. Үүнд олон шалтгаан байсан нь ойлгомжтой. Өнөөдөр бид үүнийг дахин ярих хэрэггүй. **Ирээдүйгээ харж ажиллах юм бол Хятад, Монгол хоёр улсын хооронд хамтран ажиллах боломж их байна... Манай улс БНМАУ-ын бүрэн эрх, тусгаар тогтнолыг бүрэн хүндэтгэж байна.** Монгол, Хятад хоёр нь ах дүү орнууд мөн. Гэхдээ Хятад том учраас ах нь, Монгол бага учраас дүү нь гэсэн үг биш шүү... Адил тэгш эрхтэй ах дүү орнууд юм. Бид найрсгаар харилцаж, нягт хамтран ажиллах хэрэгтэй. Бидэнд маргаантай асуудал үнэн хэрэгтэй байхгүй. ..Хоёр орны хамтын ажиллагаа нь түр зуурын биш, өнө урт хугацааны хамтын ажиллагаа юм. Харилцааг улам сайжруулах, **өнгөрснийг давтахгүй байх ёстой**” гэжээ.²¹ Ян Шанкүнь Ц.Гомбосүрэн сайдад хэлсэн үг нь Дэн Сяопинаас М.С.Горбачевт 2 сарын дараа хэлсэн “өнгөрсөнд цэг тавьж, ирээдүйгээ харж ажиллая” гэдэгтэй утга нэгтэй байсныг тэмдэглэх нь зүйтэй.

1985 оноос М.С. Горбачевын ЗХУ-д хэрэгжүүлж эхэлсэн “перейстройка” БНМАУ-д мөн шууд нөлөөлсөн билээ. Юмжаагийн Цэдэнбалыг 1984 онд огцруулж, нэг хүнийг тахин шүтэх тогтолцоог халсны дараа Жамбын Батмөнх 1989 он хүртэл БНМАУ-ын нам, төрийн эрхийг барьсан билээ. Ж. Батмөнх хэдийгээр ноён нуруу алдаагүй, хашир, тайван, аажим зангаар хөдөлж байсан боловч Монголд ардчилал хийх, зах зээлд шилжих эрс өөрчлөлт хийхийг зориглоогүй, үйл явдлыг аялдан дагасан бодлого барьж байлаа. Түүний эрх барьсан үеийг Дэн Сяопин 1982 онд төр засгийн эрхэнд гарч ирэхээс өмнөх 1976 оны дараах Хуа Гофэний богино үетэй зарим талаар адилтгаж болох юм. Гэвч Монголд өөрийн Дэн Сяопин байгаагүй, Горбачев ч байгаагүй бөгөөд Монголын шинэ үеийнхэн л санаачилгыг гартаа авч Монголоо бусад ардчилсан орны жишигээр хөгжүүлэхгүй бол олон 10 жил хөлдсөн мөсөн хунгарыг хайлуулах аргагүй байв.

Судлаач Х. Олзвой “Монгол-Хятадын харилцааны түүхийг үзвэл, энэ хоёр орон Оростой хэрхэн харилцаж байсан өнгө аясыг агуулж байснаар барахгүй, Монгол-Хятадын харилцаа нь Монгол, Зөвлөлтийн харилцааны хувьд захирагдах, харьяалагдах (subordinate) шинж чанартай явж иржээ. Үнэндээ ЗХУ хэдэн арван жилийн турш Монголын “өмгөөлөн ивээгч” буюу “давамгайллагч хүч” байсныг түүх гэрчилнэ” гэж бичжээ. Тэрбээр З.Безжиньски Хятадын нөлөөний хүрээг “хүндэтгэлийн хүрээ” гэж нэрлэснийг дурьдаад Монгол улсын үндэсний язгуур эрх ашигт нийцсэн холч, мэргэн бодлого явуулж, тэр “хүндэтгэлийн хүрээнд” багтахгүй байх, харин бид БНХАУ-ын өсөн нэмэгдэж байгаа үндэсний нийт хүч чадал, бүс нутгийн гүрнээс дэлхийн хэмжээний их гүрэн болох эрмэлзэл, нөлөөний

²¹ “Жэньминь Жибао” сонин, 1989.04.01.

хүрээгээ тэлэх, бэхжүүлэх арга барил зэргийг гүнзгий судлаж байх шаардлагатай гэжээ.²²

1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхээр Монголын гадаад харилцаанд эргэлтийн шинж чанартай өөрчлөлт гарч, Монгол улс анх удаа дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн хэмээн өөрийгөө ухаарч ажиллах болов. Гадаад бодлогодоо үндэсний эрх ашгийг дээдлэх болж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх прагматик хандлагыг голлох боллоо. Ялангуяа өмнө нь огт харьцдаггүй шахам байсан Өрнөдийн хэмээгдэх орнуудтай, мөн Ази-Номхон далайн орнуудтай харилцаагаа идэвхжүүлэв. Өмнөд хөрш БНХАУ-тай харилцаагаа бүрэн хэвийн болгож, төрийн дээд хэмжээнд харилцан айлчлалт хийж, хоёр орны худалдаа, соёл, хүмүүнлэгийн солилцоо түргэн өсөх болов. Өөрөөр хэлбэл, түүхийн өмнөх сургамжаас дүгнэлт хийж түүхээс заяасан хоёр хөрштэйгээ харилцахдаа аль нэгтэй нь хэт ойртон, нөгөө хөршдөө дайсагнах байдлыг дахин давтахгүй, аль алинтай нь сайн хөршийн, найрсаг харилцааг баримтлах болов. Мөн АНУ, Япон, Европын хамтын нийгэмлэгийн орнууд зэрэг хөгжилтэй орнуудтай тогтоосон харилцааг улам бэхжүүлж, “гуравдагч хөрш”-ийн хэмжээнд аваачих, гаднаас хөрөнгө оруулах таатай нөхцлийг бүрдүүлэх, гадаад худалдааны түнш нарыг зохистой хэмжээнд аль болох олон байлгах нь Монголын гадаад бодлогын чухал нэгэн зорилго болж тавигдаж байв.

1990-ээд оны эхэн үеийг 1910-аад онтой ямар нэгэн талаар зүйрлэж болно хэмээн “Дорно-Өрнө” сэтгүүлийн 1993 оны № 1-д хэвлүүлсэн “Монголын хувь заяаны тухай эрэгцүүлэл” өгүүлэлдээ зохиогч миний бие бичиж байж билээ. “1910-аад онд өмнөд хөрш Хятадад манжийн Чин гүрэн задарч монголчууд олон зуун жил алдагдсан төр улсаа сэргээж, Богд хаант Монгол улсаа зарлаж, үндэсний ухамсар сэргэж байсан үе байсан. Тэгвэл 1990-ээд оны эхээр умард хөрш Орост Зөвлөлт Холбоот Улс задарч, Монгол улс биеэ даасан дотоод, гадаад бодлого явуулах чадамжтай болж, дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн болж чадлаа. Түүхээс заяасан энэхүү ховорхон бололцоог бүрэн дүүрэн ашиглаж хүн төрөлхтөний сонгож авсан ардчилал, зах зээлийн зам дээр баттай зогсож чадах эсэхээс Монголын цаашдын хувь заяа шалтгаалах болно” гэж дүгнэж байв.²³

НОМ ЗҮЙ

Батбаяр. Ц. “Монголын хувь заяаны тухай эрэгцүүлэл.” Дорно Өрнө сэтгүүл, № 1. 1993

Баярхүү. Д. Жамбын Батмөнх. НЭПКО: УБ, 2015.

Сяопин Дэн вэнсюань. Дэн Сяопины түүвэр зохиол: 3-р боть. Бээжин : Жэньминь хэвлэлийн газар, 1993.

Горбачев.М. Жизнь и реформы. Книга 2. Москва, 1995.

Төмөрхүлэг.Т. Орос, Монгол, Хятад: Улс төр, дипломатын харилцаа \1949-

²² Х.Олзвой. Монгол Улсын талаар явуулж буй БНХАУ-ын геополитикийн зарим асуудал. “Алтан аргамж” сэтгүүл, 2001. № 4, 164-166-р тал.

²³ Ц. Батбаяр. Монголын хувь заяаны тухай эрэгцүүлэл. “Дорно Өрнө” сэтгүүл, 1993. № 1.

1990\, УБ., 2016.

Олзвой. Х. “Монгол Улсын талаар явуулж буй БНХАУ-ын геополитикийн зарим асуудал.” “Алтан аргамж” сэтгүүл, № 4 2001, 164-166-р тал.

Капица М.С. На разных параллелях: Записки дипломата. М., 1996.

Сайбин Кун, Сулянь Зоучу. Бээжин: Синьхуа хэвлэлийн газар, 2011.

Цичэнь Цянь. Хятадын дипломатын 10 том үйл явдлын тэмдэглэл. УБ., 2016.

Garver.W John. “The “New Type” of Sino-Soviet Relations.” Asian Survey. Vol. 29, no. 12 (December 1989): 1136-1152.

Kissinger, Henry. On China. New York: The Penguin press, 2011.